



2017 оны 04 дүгээр сарын 28  
№ 16 /973/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Монгол Улсын  
хууль

630

**Нийтийн албанд нийтийн  
болон хувийн ашиг сонирхлыг  
зохицуулах, ашиг сонирхлын  
зөрчлөөс урьдчилан сэргийлэх  
тухай хуульд нэмэлт  
оруулах тухай**

Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг

636

**Авлигатай тэмцэх газрын  
дэргэдэх Олон нийтийн  
зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай зарлигт  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын  
Үндсэн хуулийн  
цэцийн дүгнэлт

640

**Эрүүгийн байцаан шийтгэх  
хуулийн 349 дүгээр зүйлийн  
349.1 дэх хэсгийн зарим заалт  
Үндсэн хуулийн холбогдох зүйл,  
заалтыг зөрчсөн эсэх маргааныг  
хянан шийдвэрлэсэн тухай**

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

254.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	631
255.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай	632
256.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	633
257.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	634
258.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	635
259.	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	635
260.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	636
261.	Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	636
262.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	637
263.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	638
264.	Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	640
265.	Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай	640



266.	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		641
267.	Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		700
268.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		701
269.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		702
270.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		704
271.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		704
272.	Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		706
273.	Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		709
274.	Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		709
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
275.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай	Дугаар 25	711
276.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 26	711
277.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 27	712
278.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 28	714
279.	Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 29	714

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 10<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

#### **“10<sup>1</sup> дүгээр зүйл. Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт**

10<sup>1</sup>.1. Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно.

10<sup>1</sup>.2. Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлэх үүрэгтэй.

10<sup>1</sup>.3. Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

10<sup>1</sup>.4. Энэ хуулийн 10<sup>1</sup>.2 дахь хэсэгт заасан нэр дэвшигч албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол 3 сарын дотор дараахь арга хэмжээг авч, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ:



10<sup>1</sup>.4.1.нээлгэсэн банкны дансаа хаалгах;  
10<sup>1</sup>.4.2.банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах;  
10<sup>1</sup>.4.3.хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах;

10<sup>1</sup>.4.4.хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох.

10<sup>1</sup>.5.Албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөхөд энэ хуулийн 10<sup>1</sup>.1 дэх хэсэг хамаарахгүй. Хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэнэ.

10<sup>1</sup>.6.Энэ хуулийн 10<sup>1</sup>.2, 10<sup>1</sup>.4 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлсэн нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсч болзошгүйд тооцох үндэслэл болохгүй.

10<sup>1</sup>.7.Энэ хуулийн 10<sup>1</sup>.1, 10<sup>1</sup>.2, 10<sup>1</sup>.4, 10<sup>1</sup>.5 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь албан тушаалтныг эгүүлэн татах үндэслэл болно.”

**2 дугаар зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх заалтын “11,” гэсний өмнө “10<sup>1</sup>.1, 10<sup>1</sup>.2, 10<sup>1</sup>.4, 10<sup>1</sup>.5 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.7 дахь хэсэг нэмсүгэй:

“10.7.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10<sup>1.4</sup> дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2018-2019 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2017 он	2018 он	2019 он
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	-0.2	1.8	8.1
2 Хэрэглээний үнийн индексийн түвшин	6.1	6.1	6.9
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6,035.7	6,808.4	7,803.1
	23.2	24.6	24.9



4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	8,750.2	9,451.0	9,971.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	33.6	34.1	31.8
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	-944.2	700.8	520.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-3.6	2.5	1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,714.4	-2,642.6	-2,167.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-10.4	-9.5	-6.9
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,579.8	1,623.0	1,875.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6.1	5.9	6.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,144.2	22,155.2	23,547.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	85.0	80.0	75.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	470.0	499.6	531.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.8	1.8	1.7

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “бусад зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “1 дүгээр зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчилсүгэй.



**2 дугаар зүйл.**2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “2020” гэснийг “2024” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН  
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.5.Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “18 өдөр” гэснийг “15 өдөр” гэж, мөн зүйлийн 7.1.10 дахь заалтын “цалин хөлс” гэснийг “сургалтын тэтгэлэг” гэж тус тус өөрчилсүгэй.





**3 дугаар зүйл.**Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.17, 7.1.21 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ  
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “60 нас” гэснийг “65 нас” гэж, “55 нас” гэснийг “60 нас” гэж, “эмэгтэй” гэснийг “даатгуулагч” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “50 нас” гэснийг “55 нас” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй” гэснийг “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан насанд хүрсэн даатгуулагч” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчилсүгэй:

“12.1.1.65 болон түүнээс дээш настай иргэн;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.1-д заасан нийгмийн халамжийн тэтгэвэр авах насны болзлыг доор дурдсанаар тогтоон хэрэгжүүлнэ:

Тэтгэвэр тогтоолгох он	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагч болон Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.1-д заасан иргэний тэтгэвэр тогтоолгох нас		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох нас
	эрэгтэй	эмэгтэй	эмэгтэй
2017	60 нас	55 нас	50 нас
2018	60 нас 6 сар	55 нас 6 сар	50 нас 6 сар
2019	61 нас	56 нас	51 нас
2020	61 нас 6 сар	56 нас 6 сар	51 нас 6 сар
2021	62 нас	57 нас	52 нас
2022	62 нас 6 сар	57 нас 6 сар	52 нас 6 сар
2023	63 нас	58 нас	53 нас
2024	63 нас 6 сар	58 нас 6 сар	53 нас 6 сар
2025	64 нас	59 нас	54 нас
2026	64 нас 6 сар	59 нас 6 сар	54 нас 6 сар
2027	65 нас	60 нас	55 нас
2028	-	60 нас 6 сар	-
2029	-	61 нас	-
2030	-	61 нас 6 сар	-
2031	-	62 нас	-
2032	-	62 нас 6 сар	-
2033	-	63 нас	-
2034	-	63 нас 6 сар	-
2035	-	64 нас	-
2036	-	64 нас 6 сар	-
2037	-	65 нас	-



**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан өндөр насны тэтгэврийг өөрийн хүсэлтээр 60 насандаа тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2034 он хүртэл жил бүр 3 сараар нэмэгдүүлнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмсүгэй:

**“6 дугаар зүйл.**2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласнаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн тэтгэврийн эрхийг хэвээр хадгална.”

**2 дугаар зүйл.**1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“2 дугаар зүйл.**Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг доор дурдсанаар тогтооно:

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Тэтгэвэр тогтоолгох он	Хөдөлмөрийн халуун нөхцөлд ажилласан даатгуулагч		Газрын дор ажилласан даатгуулагч
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй
2017	50 нас	45 нас	50 нас
2018	50 нас 6 сар	45 нас 6 сар	50 нас 6 сар
2019	51 нас	46 нас	51 нас
2020	51 нас 6 сар	46 нас 6 сар	51 нас 6 сар
2021	52 нас	47 нас	52 нас
2022	52 нас 6 сар	47 нас 6 сар	52 нас 6 сар
2023	53 нас	48 нас	53 нас
2024	53 нас 6 сар	48 нас 6 сар	53 нас 6 сар
2025	54 нас	49 нас	54 нас
2026	54 нас 6 сар	49 нас 6 сар	54 нас 6 сар
2027	55 нас	50 нас	55 нас

2/Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Тэтгэвэр тогтоолгох он	Эрэгтэй	Эмэгтэй
2017	50 нас	45 нас
2018	50 нас 6 сар	45 нас 6 сар
2019	51 нас	46 нас
2020	51 нас 6 сар	46 нас 6 сар
2021	52 нас	47 нас
2022	52 нас 6 сар	47 нас 6 сар
2023	53 нас	48 нас
2024	53 нас 6 сар	48 нас 6 сар
2025	54 нас	49 нас
2026	54 нас 6 сар	49 нас 6 сар
2027	55 нас	50 нас

3/Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас:

Тэтгэвэр тогтоолгох он	Эрэгтэй	Эмэгтэй
2017	55 нас	50 нас
2018	55 нас 6 сар	50 нас 6 сар
2019	56 нас	51 нас
2020	56 нас 6 сар	51 нас 6 сар
2021	57 нас	52 нас
2022	57 нас 6 сар	52 нас 6 сар
2023	58 нас	53 нас
2024	58 нас 6 сар	53 нас 6 сар
2025	59 нас	54 нас
2026	59 нас 6 сар	54 нас 6 сар
2027	60 нас	55 нас



**3 дугаар зүйл.**1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн дугаарыг “7” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “7.0” гэснийг “9.5” гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “7.0” гэснийг “9.5” гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “10.0” гэснийг “12.7” гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний “10.0” гэснийг “12.5” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “10 хувиас” гэснийг “12.5 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ  
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1994 оны 06 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 3<sup>д</sup> дугаар зүйл нэмсүгэй:



**“3<sup>д</sup> дугаар зүйл. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ**

1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2017 онд тус бүр 7.0 хувь, 2018 онд тус бүр 8.0 хувь, 2019 онд тус бүр 8.5 хувь, 2020 оноос эхлэн тус бүр 9.5 хувьтай байна.

2. Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалд сард төлбөл зохих шимтгэлийн доод хэмжээ нь 2017 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10.0 хувиас, 2018 онд 11.0 хувиас, 2019 онд 11.5 хувиас, 2020 оноос эхлэн 12.5 хувиас багагүй байна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл нэмсүгэй:

**1/22<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“22<sup>1</sup> дүгээр зүйл.** Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2017 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшууллыг 5 дугаар хавсралтаар баталсугай.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн дараахь зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйл:**

**“3 дугаар зүйл.** Монгол Улсын төсөвт 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:



Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b> Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	<b>2,717.8</b> 2,717.8
2	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b> Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	<b>549.1</b> 549.1
3	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b> Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>60.0</b> 60.0
4	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b> Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>822.4</b> 822.4
5	<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b> Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>595.7</b> 589.7 6.0
6	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b> Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Үүнээс: Ирээдүйн өв санд Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>127,129.6</b> 2,500.0 121,207.1 9,466.0 3,422.5
7	<b>Авлигатай тэмцэх газар</b> Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	<b>105.8</b> 105.8
8	<b>Монгол Улсын Шадар сайд</b> Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Стандарт, хэмжил зүйн газар Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>15,133.7</b> 2,252.5 2,486.0 5,606.2 4,789.1
9	<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b> Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>1,023.7</b> 881.2 142.5
10	<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b> Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>24,103.4</b> 23,822.9 280.5
11	<b>Гадаад харилцааны сайд</b> Дипломат төлөөлөгчийн газрууд Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>12,050.0</b> 10,500.0 1,550.0
12	<b>Сангийн сайд</b> Татварын ерөнхий газар Үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Ирээдүйн өв санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>3,714,999.8</b> 1,907,352.0 208,800.7 257,342.4 1,632,435.8 16,529.3 121,427.0 33,936.2 3,319.5



13	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>60,633.1</b>
	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар	15,900.0
	Цагдаагийн ерөнхий газар	3,487.5
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	20,600.7
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,100.7
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	16,544.1
14	<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>59,006.0</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,871.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	54,134.5
15	<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b>	<b>33,105.3</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	28,131.9
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,973.4
16	<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	<b>155,288.9</b>
	Иргэний нисэхийн ерөнхий газар	144,921.0
	Зам, тээврийн хөгжлийн яам	190.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	8,277.1
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,900.8
17	<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>2,584.7</b>
	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	1,765.2
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	819.4
18	<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	<b>303,633.1</b>
	Ашигт малтмал, газрын тосны газар	293,323.1
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	3,352.3
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	6,957.8
19	<b>Улсын ерөнхий прокурор</b>	<b>887.6</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	887.6
20	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>161,524.3</b>
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	54,000.0
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	7,126.1
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	100,398.2
21	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>80,144.2</b>
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	420.0
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	527.2
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	13,739.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	65,458.0
22	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>215,344.4</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	176,796.5
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	13,875.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	24,672.5
23	<b>Эрчим хүчний сайд</b>	<b>5,435.9</b>
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	5,435.9





### 2/5 дугаар зүйл:

**5 дугаар зүйл.** Монгол Улсын төсвөөс 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b> Урсгал зардал	<b>4,546.7</b> 4,546.7
2	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>27,768.4</b> 23,362.6 1,688.0 2,717.8
3	<b>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга</b> Урсгал зардал	<b>1,585.4</b> 1,585.4
4	<b>Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч</b> Урсгал зардал	<b>4,051.9</b> 4,051.9
5	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b> Урсгал зардал	<b>46,295.1</b> 46,295.1
6	<b>Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга</b> Урсгал зардал	<b>791.8</b> 791.8
7	<b>Улсын ерөнхий прокурор</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>26,967.2</b> 25,991.3 88.3 887.6
8	<b>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга</b> Урсгал зардал	<b>1,984.3</b> 1,984.3
9	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b> Урсгал зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>9,312.5</b> 8,763.4 549.1
10	<b>Авлигатай тэмцэх газрын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>9,351.6</b> 8,394.4 851.4 105.8
11	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b> Урсгал зардал	<b>2,514.7</b> 2,514.7
12	<b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b> Урсгал зардал	<b>725.8</b> 725.8
13	<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b> Урсгал зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>7,564.6</b> 6,974.9 589.7

14	<b>Сонгуулийн ерөнхий хорооны дарга</b> Урсгал зардал	<b>15,752.6</b> 15,752.6
15	<b>Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга</b> Урсгал зардал	<b>461.2</b> 461.2
16	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>165,710.9</b> 85,188.1 80,522.8
17	<b>Монгол Улсын Шадар сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>115,840.9</b> 91,867.7 13,367.0 10,606.2
18	<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>21,590.3</b> 11,635.4 3,857.9 6,097.0
19	<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>74,003.3</b> 43,528.1 6,652.3 23,822.9
20	<b>Гадаад харилцааны сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>63,596.8</b> 62,896.8 700.0
21	<b>Сангийн сайд</b> Урсгал зардал Дотоод эх үүсвэрээс олгох зээл Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт	<b>10,299,113.7</b> 1,492,383.7 143,446.4 10,481.7 151,496.6 8,331,592.6 169,712.7
22	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>442,680.9</b> 415,003.7 27,663.2 14.1
23	<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	<b>466,133.5</b> 9,535.8 133,982.5 322,615.2
24	<b>Батлан хамгаалахын сайд</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>207,615.7</b> 204,922.6 2,693.1
25	<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд</b> Урсгал зардал	<b>1,357,294.9</b> 1,047,244.0



	<p>Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Дотоод эх үүсвэрээс олгох зээл</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p>276,192.8</p> <p>589,691.1</p> <p>43,220.7</p> <p>10,822.0</p> <p>97,126.9</p> <p>104,136.2</p> <p>108,787.7</p>
26	<p><b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b></p> <p>Урсгал зардал</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p><b>25,207.5</b></p> <p>8,519.3</p> <p>13,335.9</p> <p>3,352.3</p>
27	<p><b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b></p> <p>Урсгал зардал</p> <p>Дотоод эх үүсвэрээс олгох зээл</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p><b>237,787.9</b></p> <p>95,169.1</p> <p>51,709.0</p> <p>49,384.6</p> <p>41,525.1</p>
28	<p><b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b></p> <p>Урсгал зардал</p> <p>Үүнээс: Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Дотоод эх үүсвэрээс олгох зээл</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p><b>1,072,409.4</b></p> <p>1,005,273.5</p> <p>6,118.3</p> <p>7,679.1</p> <p>20,000.0</p> <p>39,456.8</p>
29	<p><b>Эрүүл мэндийн сайд</b></p> <p>Урсгал зардал</p> <p>Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p><b>673,530.3</b></p> <p>569,784.5</p> <p>107,230.7</p> <p>49,422.1</p> <p>54,323.7</p>
30	<p><b>Эрчим хүчний сайд</b></p> <p>Урсгал зардал</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p><b>149,527.0</b></p> <p>19,855.1</p> <p>32,439.0</p> <p>97,233.0</p>
31	<p><b>Барилга, хот байгуулалтын сайд</b></p> <p>Урсгал зардал</p> <p>Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг</p> <p>Хөрөнгийн зардал</p> <p>Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал</p>	<p><b>125,277.8</b></p> <p>11,909.0</p> <p>6,961.8</p> <p>81,294.1</p> <p>32,074.8</p>

**3/16-18 дугаар зүйл:**

**16 дугаар зүйл.**Монгол Улсын 2017 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	11,706.1
2	Баян-Өлгий	10,646.2
3	Баянхонгор	11,082.6
4	Говь-Алтай	8,170.0
5	Дорнод	2,497.5
6	Дундговь	5,719.0
7	Завхан	9,356.2
8	Өвөрхангай	11,415.4
9	Сүхбаатар	5,086.5
10	Сэлэнгэ	3,041.5
11	Төв	7,568.7
12	Увс	11,071.4
13	Ховд	7,725.5
14	Хөвсгөл	17,661.4
15	Хэнтий	8,435.7
<b>Нийт дүн</b>		<b>131,183.7</b>

**17 дугаар зүйл.**2017 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Булган	692.4
2	Дорноговь	1,103.5
3	Өмнөговь	30,204.0
4	Дархан-Уул	408.1
5	Улаанбаатар	159,705.5
6	Орхон	13,971.7
7	Говьсүмбэр	223.2
<b>Нийт дүн</b>		<b>206,308.3</b>

**18 дугаар зүйл.**2017 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг доор дурдсанаар баталсугай:



Д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,987.2 627.8
2	Баян-Өлгий Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,654.4 443.1
3	Баянхонгор Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,163.3 734.9
4	Булган Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,745.0 603.6
5	Говь-Алтай Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,185.0 603.2
6	Дорноговь Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,307.0 341.9
7	Дорнод Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,084.1 557.1
8	Дундговь Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,846.8 353.6
9	Завхан Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,708.7 432.5
10	Өвөрхангай Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,253.9 672.1
11	Өмнөговь Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	3,190.3 443.8
12	Сүхбаатар Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,554.8 536.0
13	Сэлэнгэ Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,139.6 725.2
14	Төв Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,808.2 631.3
15	Увс Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,709.8 542.8
16	Ховд Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,778.3 690.8
17	Хөвсгөл Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	2,186.4 1,150.6
18	Хэнтий Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,995.4 601.1
19	Дархан-Уул Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,773.3 1,275.3
20	Улаанбаатар Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	11,822.6 319.0
21	Орхон Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,941.3 1,006.3
22	Говьсүмбэр Үүнээс: Урсгал зарлагыг санхүүжүүлэх	1,178.1 170.2
<b>Нийт дүн</b>		<b>53,013.5</b>

**3 дугаар зүйл.** Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралтаар өөрчлөн найруулсугай.

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар өөрчлөн найруулсугай.

**5 дугаар зүйл.** Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4,378,889.9” гэснийг “4,276,367.5” гэж, 6 дугаар зүйлийн “6,759,169.6” гэснийг “6,959,661.7” гэж, 7 дугаар зүйлийн “250,654.7” гэснийг “492,850.8” гэж, 8 дугаар зүйлийн “71,518.6” гэснийг “70,933.7” гэж, 10 дугаар зүйлийн “8,397.8” гэснийг “208,800.7” гэж, 11 дүгээр зүйлийн “221,651.0” гэснийг “266,808.4” гэж, 13 дугаар зүйлийн “61,651.0” гэснийг “106,808.4” гэж, 14 дүгээр зүйлийн “2,336,245.7” гэснийг “4,610,299.7” гэж тус тус өөрчилсүгэй.

**6 дугаар зүйл.** Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 9, 22 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай  
хуулийн 5 дугаар хавсралт

**ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРӨӨС  
2017 ОНД СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД  
ОЛГОХ УРАМШУУЛАЛ**

Д/д	Аймаг, сум	Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшууллын хэмжээ /мянган төгрөгөөр/
1	<b>Архангай</b>	<b>251,651.5</b>
	Батцэнгэл сум	23,151.4
	Булган сум	21,030.0
	Өгийнуур сум	19,453.6
	Өлзийт сум	20,369.5
	Тариат сум	26,398.0
	Хайрхан сум	24,215.0
	Хотонт сум	22,071.4
	Цахир сум	25,959.8
	Цэцэрлэг сум	24,526.4
	Эрдэнэбулган сум	44,476.6



2	<b>Баян-Өлгий</b> Алтай сум Өлгий сум Толбо сум	<b>107,954.4</b> 27,446.2 55,081.6 25,426.6
3	<b>Баянхонгор</b> Баацагаан сум Бууцагаан сум Галуут сум Жаргалант сум Заг сум Өлзийт сум Хүрээмарал сум Шинэжинст сум	<b>262,225.1</b> 31,009.0 35,434.1 27,645.3 32,411.4 31,504.9 25,762.0 32,745.6 45,712.7
4	<b>Булган</b> Баян-Агт сум Булган сум Бүрэгхангай сум Гурванбулаг сум Могод сум Орхон сум Рашаант сум Сэлэнгэ сум Хангал сум Хишиг-Өндөр сум	<b>321,583.4</b> 31,820.7 46,209.3 29,434.0 30,232.5 29,737.8 30,994.8 29,148.7 34,948.3 31,684.5 27,372.9
5	<b>Говь-Алтай</b> Баян-Уул сум Дэлгэр сум Жаргалан сум Төгрөг сум Хөхморьт сум Цогт сум Чандмань сум Шарга сум Эрдэнэ сум	<b>361,174.5</b> 40,515.7 38,132.4 32,715.9 34,232.5 43,982.3 50,048.8 32,499.2 31,632.6 57,415.3
6	<b>Дорноговь</b> Айраг сум Алтанширээ сум Дэлгэрэх сум Замын-Үүд сум Иххэт сум Мандах сум Өргөн сум Сайншанд сум Сайхандулаан сум Улаанбадрах сум Хатанбулаг сум Хөвсгөл сум Эрдэнэ сум	<b>687,031.4</b> 48,492.4 48,492.4 43,624.3 78,668.3 43,466.7 64,141.6 43,331.5 75,430.2 40,251.5 29,927.1 62,050.1 49,605.4 59,550.0

7	<b>Дорнод</b>		<b>364,650.1</b>
		Баян-Уул сум	36,275.1
		Булган сум	39,302.6
		Дашбалбар сум	41,226.3
		Сэргэлэн сум	23,994.5
		Хэрлэн сум	196,070.9
		Чулуунхороот сум	27,780.7
8	<b>Дундговь</b>		<b>399,093.7</b>
		Адаацаг сум	34,229.3
		Баянжаргалан сум	30,578.7
		Говь-Угтаал сум	31,510.6
		Дэлгэрхангай сум	38,587.9
		Дэрэн сум	34,351.4
		Луус сум	32,791.7
		Өндөршил сум	34,449.6
		Сайхан-Овоо сум	39,434.8
		Хулд сум	39,804.1
	Цагаандэлгэр сум	28,780.3	
	Эрдэнэдалай сум	54,575.6	
9	<b>Завхан</b>		<b>97,052.5</b>
		Дөрвөлжин сум	26,882.5
		Идэр сум	19,190.0
		Отгон сум	22,207.5
	Тэс сум	28,772.5	
10	<b>Өвөрхангай</b>		<b>353,484.6</b>
		Арвайхээр сум	56,851.1
		Бат-Өлзий сум	26,575.7
		Бүрд сум	21,765.3
		Гучин ус сум	27,382.0
		Есөнзүйл сум	20,232.2
		Нарийн тээл сум	23,557.2
		Өлзийт сум	20,044.7
		Сант сум	21,453.6
		Тарагт сум	23,135.8
		Төгрөг сум	28,361.7
		Хайрхандулаан сум	25,844.5
		Хархорин сум	33,963.4
	Хужирт сум	24,317.7	
11	<b>Өмнөговь</b>		<b>1,425,515.6</b>
		Баяндалай сум	67,284.8
		Баян-Овоо сум	93,139.1
		Булган сум	51,888.8
		Мандал-Овоо сум	110,692.8
		Манлай сум	65,186.9
		Ноён сум	157,190.8
		Номгон сум	97,275.6
		Сэврэй сум	44,340.3
		Ханбогд сум	114,335.3
		Ханхонгор сум	67,457.0
		Хүрмэн сум	67,074.2
		Цогт-Овоо сум	39,579.1
	Цогтцэций сум	450,071.0	





12	<b>Сүхбаатар</b>	Дарьганга сум	<b>36,680.9</b> 36,680.9
	<b>Сэлэнгэ</b>		<b>529,035.3</b>
		Алтанбулаг сум	12,250.0
		Баруунбүрэн сум	58,638.0
		Баянгол сум	7,782.9
		Жавхлант сум	21,937.0
		Зүүнбүрэн сум	40,203.2
		Орхон сум	23,722.8
		Орхонтуул сум	44,698.7
		Сайхан сум	47,235.6
		Сант сум	31,530.3
		Сүхбаатар сум	37,733.3
		Түшиг сум	51,876.8
		Хушаат сум	40,193.7
		Хүдэр сум	12,386.8
		Цагааннуур сум	57,503.8
		Шаамар сум	41,342.6
	<b>Төв</b>		<b>233,387.3</b>
		Баянжаргалан сум	29,641.3
		Заамар сум	165,426.2
		Мөнгөнморьт сум	20,654.2
		Эрдэнэсант сум	17,665.7
	<b>Увс</b>		<b>130,562.7</b>
		Бөхмөрөн сум	17,001.0
		Давст сум	17,510.4
		Зүүнговь сум	15,554.8
		Малчин сум	14,663.4
		Тариалан сум	15,504.1
		Түргэн сум	11,528.9
		Ховд сум	15,972.8
		Цагаанхайрхан сум	22,827.3
	<b>Ховд</b>		<b>64,586.5</b>
		Буянт сум	22,506.5
		Зэрэг сум	20,540.0
		Мөнххайрхан сум	21,540.0
	<b>Хөвсгөл</b>		<b>199,881.5</b>
		Галт сум	20,330.1
		Жаргалант сум	21,057.2
		Мөрөн сум	48,846.6
		Рэнчинлхүмбэ сум	26,643.6
		Тариалан сум	20,424.7
		Түнэл сум	19,382.5
		Цагаан-Уул сум	21,807.8
		Эрдэнэбулган сум	21,389.1
	<b>Хэнтий</b>		<b>370,150.0</b>
		Батноров сум	39,275.0
		Батширээт сум	39,350.0
		Баян-Адарга сум	30,875.0
		Баян-Овоо сум	31,050.0
		Биндэр сум	37,775.0
		Бор-Өндөр сум	45,475.0
		Галшар сум	36,275.0
		Дархан сум	31,250.0
		Жаргалтхаан сум	27,000.0
		Мөрөн сум	23,375.0
		Цэнхэрмандал сум	28,450.0

19	<b>Дархан</b>	Дархан сум	<b>352,355.9</b> 352,355.9
20	<b>Орхон</b>	Баян-Өндөр сум	<b>362,085.5</b> 362,085.5
21	<b>Говьсүмбэр</b>	Сүмбэр сум Шивээговь сум	<b>241,857.7</b> 152,608.6 89,249.1
<b>Нийт</b>			<b>7,152,000.0</b>

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
<b>I</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b>			<b>1,688.0</b>	<b>1,688.0</b>
<b>I.3</b>	<b>III.Тоног төхөөрөмж</b>			<b>1,688.0</b>	<b>1,688.0</b>
	Шинэ			1,688.0	1,688.0
I.3.1	Улсын Их Хурлын техник, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2017	2017	1,688.0	1,688.0
<b>II</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>			<b>8,100.0</b>	<b>2,778.0</b>
<b>II.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>8,100.0</b>	<b>2,778.0</b>
	Шилжих			8,100.0	2,778.0
II.1.1	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид хуримтлагдсан лагийг боловсруулах дамжлага нэмэх, ашиглалтад оруулах /Улаанбаатар/	2016	2017	8,100.0	2,778.0
<b>III</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД</b>			<b>45,243.4</b>	<b>5,287.3</b>
<b>III.1</b>	<b>Онцгой байдлын ерөнхий газар</b>			<b>36,706.9</b>	<b>4,667.2</b>



<b>III.1.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>35,906.9</b>	<b>3,867.2</b>
	Шилжих			35,906.9	3,867.2
III.1.1.1	Аврах гал унтраах ангийн барилга /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2014	2017	1,250.0	383.6
III.1.1.2	Аврах гал унтраах ангийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2013	2018	3,262.5	500.0
III.1.1.3	Аврах гал унтраах ангийн барилга /Дархан-Уул, Дархан сум/	2013	2017	3,302.5	630.1
III.1.1.4	Аврах гал унтраах ангийн барилга /Сэлэнгэ, Мандал сум/	2013	2017	3,302.5	1,042.8
III.1.1.5	Аврах гал унтраах ангийн барилга /Төв, Зуунмод сум/	2013	2018	2,700.0	591.8
III.1.1.6	Аврах гал унтраах ангийн барилга /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2013	2017	2,089.4	685.2
III.1.1.7	Онцгой байдлын албаны командын байрын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2015	2017	20,000.0	33.7
XV.1.1	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2019	20,000.0	700.0
XV.1.2	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа Түлэнхийн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2013	2019	26,000.0	500.0
XV.1.3	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2012	2017	16,473.7	4,045.6
XV.1.4	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2017	1,557.0	241.2
XV.1.5	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2011	2017	5,019.0	1,994.5



XV.1.6	Нэгдсэн эмнэлгийн барилга, 50 ор /Ховд, Булган сум/	2015	2018	6,660.0	2,000.0
XV.1.7	Говийн бүсийн оношилгоо эмчилгээний төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2012	2018	7,247.7	1,950.0
XV.1.8	Хүүхдийн эмнэлгийн барилгын засвар, өргөтгөл /Орхон, Баян-Өндөр сум/	2015	2018	4,000.0	1,473.0
XV.1.9	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Хөвсгөл, Их-Уул сум/	2014	2017	1,248.6	416.4
XV.1.10	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, /Хөвсгөл, Түнэл сум/	2015	2018	1,310.0	269.0
XV.1.11	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2018	1,112.7	200.0
XV.1.12	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2014	2017	1,112.7	250.0
XV.1.13	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 14 ор /Баянхонгор, Баянцагаан сум/	2013	2018	820.0	200.0
XV.1.14	Нэгдсэн эмнэлгийн угаалга, ариутгалын барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2016	2017	550.0	550.0
XV.1.15	Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/	2011	2018	3,524.4	850.0
XV.1.16	Геронтологийн төв, 60 ор /Улаанбаатар/	2011	2019	7,392.9	300.0
XV.1.17	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/	2010	2017	1,013.4	543.6
XV.1.18	Эрүүл мэндийн төвийн барилга /Дундговь, Дэлгэрхангай сум/	2012	2017	1,365.0	1,165.0
XV.1.19	Хавдар судлалын үндэсний төвийн өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2017	5,597.4	173.8





XV.1.20	Бельгийн Вант Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах төсөл /Ховд, Жаргалант сум/	2013	2019	8,700.0	1,000.0
XV.1.21	Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төслийн монголын талын хөрөнгө	2014	2020	20,000.0	2,400.0
<b>XV.2</b>	<b>II.Их засвар</b>			<b>8,000.0</b>	<b>8,000.0</b>
	Шинэ			8,000.0	8,000.0
XV.2.1	Эрүүл мэндийн салбарын их засвар /улсын хэмжээнд/	2017	2017	8,000.0	8,000.0
<b>XV.3</b>	<b>III.Тоног төхөөрөмж</b>			<b>36,800.0</b>	<b>20,200.0</b>
	Шилжих			<b>28,800.0</b>	<b>12,200.0</b>
XV.3.1	Хавдар судлалын үндэсний төвийн сити томографын аппарат /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2016	2018	2,100.0	1,600.0
XV.3.2	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр 4, 5	2011	2020	26,700.0	10,600.0
	Шинэ			8,000.0	8,000.0
XV.3.3	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2017	2017	8,000.0	8,000.0
<b>XVI</b>	<b>ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>			<b>181,431.3</b>	<b>32,439.0</b>
<b>XVI.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>175,131.3</b>	<b>27,439.0</b>



	Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц			164,531.3	23,989.0
	Шилжих			164,531.3	23,989.0
XVI.1.1	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэлжлэл /улсын хэмжээнд/	2014	2018	22,291.8	7,350.0
XVI.1.2	Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл /Увс, Өлгий сум/	2016	2017	231.0	45.4
XVI.1.3	Гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Баян-Өлгий, Өлгий сум/	2016	2017	995.0	497.5
XVI.1.4	Дулааны цахилгаан станц 4-өөс У-18 хүртэлх /Москва хорооллын урд тал хүртэл/ 4.2 км, Ш 800-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил	2014	2018	16,987.3	2,722.2
XVI.1.5	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2014	2017	3,940.0	334.6
XVI.1.6	Багануур-Цэнхэрмандалын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Хэнтий/	2015	2017	3,415.8	552.9
XVI.1.7	12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 Ш 400 мм голчтой шугамыг 2 Ш 500 мм болгон өргөтгөх, 3х500х70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт /Улаанбаатар/	2015	2017	7,296.0	1,597.3



XVI.1.8	1 в магистральный ТК-1893-с ТК-117 цэг хүртэлх 1500 метр 2x500 мм-ын шугамыг 2x700 мм шугам болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2017	2,998.6	7.1
XVI.1.9	Багануурын дулааны станцын сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2017	3,100.0	14.3
XVI.1.10	Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистраль шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2013	2017	3,538.3	182.3
XVI.1.11	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /Улаанбаатар/	2014	2017	9,000.0	72.4
XVI.1.12	Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	2014	2017	8,400.0	1,289.7
XVI.1.13	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	2014	2017	17,000.0	1,109.7
XVI.1.14	Эрчим хүчний төвлөрсөн системд холбох, 3 сум /Дорноговь, Хатанбулаг, Мандах сум, Говь-Алтай, Бугат сум/	2015	2017	11,928.0	303.7



XVI.1.15	Амгалан дулааны станц 348 МВт-ын туршилт, тохируулгын ажил /Улаанбаатар/	2015	2017	3,988.3	1,010.6
XVI.1.16	Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	9,267.0	727.6
XVI.1.17	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2x25 МВА чадалтай компьютерийн хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2x2 км шилэн кабель бүхий аянгын тросстой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2017	7,291.0	5.7
XVI.1.18	Сонгинохайрхан дүүргийн 5, 6 дугаар хороо, Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 2 Ш 300/400 мм-ийн голчтой 1.1 км шугам, 1 ширхэг ус, дулаан дамжуулах төв, Ш 150 мм-ийн голчтой 137 метр шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны Ш 500 мм-ийн 1235 метр шугам, бохир усны Ш 200-300 мм-ийн 1788 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	2014	2018	9,854.0	987.3



XVI.1.19	Шар хад, Амгалан орчмын бохир ус татан зайлуулах, ариутгах татуургын шугам сүлжээний ажил	2014	2017	2,224.0	343.4
XVI.1.20	220 кВ-ын Улаанбаатар дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станц хүртэлх 110 кВ-ын 9.7 км 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил	2014	2017	938.4	311.9
XVI.1.21	110 кВ-ын Баянгол дэд станцаас 110 кВ-ын Радио телевиз дэд станц хүртэлх 110 кВ-ын 24 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	814.9	394.1
XVI.1.22	220 кВ-ын Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВ-ын 50 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	2,139.7	583.9
XVI.1.23	110/35/10 кВ-ын 2*40 МВа дэд станцаас 14 дүгээр хорооллын дэд станцын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам хүртэлх 110 кВ-ын 2 км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	2014	2017	2,100.0	753.1
XVI.1.24	Сонгино 220/110/35 кВ-ын 2х125 МВа дэд станц, 220 кВ-ын 10 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014	2017	4,698.0	1,182.7



XVI.1.25	Баянголын амны Баянгол хорооллын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 2.2 км, дэд станц, 110/35/10 кВ, 2х40 МВа /Улаанбаатар/	2014	2017	2,291.0	1,067.5
XVI.1.26	Баянголын амны 4 дүгээр ээлжийн дулааны ажил	2013	2017	2,925.8	126.7
XVI.1.27	Мардай-Чулуунхороот сумын 35 кВ-ын 160 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2012	2017	4,397.4	346.5
XVI.1.28	Холбооны 2 яндантай 2100 метр сувагчлалын зураг төсөл, барилга угсралтын ажил	2015	2017	252.0	59.0
XVI.1.29	Амгалан дулааны станцын ахуйн хэрэгцээний цэвэр усан хангамжийн угсралтын ажил	2014	2017	228.0	9.9
	<b>Гадаадын зээлээр хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр</b>			<b>10,600.0</b>	<b>3,450.0</b>
	Шилжих			10,600.0	3,450.0
XVI.1.30	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжих Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	2015	2017	10,600.0	3,450.0
<b>XVI.2</b>	<b>II.Их засвар</b>			<b>6,300.0</b>	<b>5,000.0</b>
	Шинэ			6,300.0	5,000.0
XVI.2.1	Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл /Улаанбаатар/	2017	2018	6,300.0	5,000.0



<b>XVII</b>	<b>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР</b>			<b>1,031.4</b>	<b>851.4</b>
<b>XVII.2</b>	<b>II.Их засвар</b>			<b>1,031.4</b>	<b>851.4</b>
	Шилжих			1,031.4	851.4
XVII.2.1	Авлигатай тэмцэх газрын “В” байрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2016	2017	1,031.4	851.4
<b>XVIII</b>	<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>			<b>952.7</b>	<b>88.3</b>
<b>XVIII.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>952.7</b>	<b>88.3</b>
	Шилжих			952.7	88.3
XVIII.1.1	Улсын ерөнхий прокурорын газрын архивын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2012	2017	952.7	88.3
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>2,355,041.6</b>	<b>492,850.8</b>

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” КОНЦЕССЫН ТӨРЛӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
<b>I</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>			<b>352,113.9</b>	<b>70,933.7</b>
<b>I.1</b>	<b>Үндэсний хөгжлийн газар</b>			<b>352,113.9</b>	<b>70,933.7</b>
	<b>Концессын төслийн эргэн төлөлт</b>			<b>352,113.9</b>	<b>70,933.7</b>
<b>I.1.1</b>	<b>I.Хөрөнгө оруулалт</b>			<b>352,113.9</b>	<b>70,933.7</b>
	Шилжих			352,113.9	70,933.7



I.1.1.1	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14 дүгээр сургууль/	2016	2017	10,787.0	10,787.0
I.1.1.2	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/	2015	2018	14,884.5	5,581.7
I.1.1.3	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 73 дугаар сургууль/	2015	2018	10,736.3	7,515.4
I.1.1.4	Сургуулийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 32 дугаар сургууль/	2016	2017	5,800.0	5,800.0
I.1.1.5	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/	2016	2017	1,386.6	797.3
I.1.1.6	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/	2016	2017	2,050.3	2,050.3
I.1.1.7	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	2016	2018	2,357.9	1,687.9
I.1.1.8	Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон дахь гүүрийн барилгын ажил	2016	2018	1,949.9	1,365.0
I.1.1.9	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам	2015	2019	117,042.0	10,517.1
I.1.1.10	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам	2015	2019	176,405.4	16,118.0
I.1.1.11	Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто замын ажил	2015	2017	6,952.0	6,952.0
I.1.1.12	Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3,4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих	2016	2017	1,762.0	1,762.0
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>352,113.9</b>	<b>70,933.7</b>





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“3 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>1,412,606.3</b>
	1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	514,316.3
	1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	518,780.7
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	159,367.1
	1.4.Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	0.3
	1.5.Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	52.0
	1.6.Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	58,680.5
	1.7.Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	59,352.7
	1.8.Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	27,326.8
	1.9.Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,078.2
	1.10.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	978.0
1.11.Бусад орлого	70,673.8	
2	<b>Сангийн сайд</b>	<b>587,257.2</b>
	2.1.Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	587,257.2
<b>Нийт орлого</b>		<b>1,999,863.5</b>

**4 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:



Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	1,404,356.2
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	109,210.2
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	31,495.4
	1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	29,719.1
	1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	297,436.6
	1.6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны төлбөр	117.6
	1.7.Үйл ажиллагааны урсгал зардал	19,416.4
<b>Нийт зарлага</b>		<b>1,891,751.5</b>

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9 дэх хэсэг нэмсүгэй:

“19.9.Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.”

**2 дугаар зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “2020” гэснийг “2023” гэж, 19.6 дахь хэсгийн “, 2017 онд 9.9 хувиас, 2018 онд 7.5 хувиас, 2019 онд 5.5 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2020 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй” гэснийг “хэтрүүлэхгүй” гэж тус тус өөрчилсүгэй.



**3 дугаар зүйл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/12 дугаар зүйлийн 12.1.22 дахь заалт:**

“12.1.22.концессын зүйлийн жагсаалтын төслийг энэ хуулийн 32.2-т заасан танилцуулгад тусган, энэ хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдэл болон тухайн жилийн төсвийн хязгаарт нийцсэн эсэхийг хянан, нийцсэн бол зөвшөөрөл олгох.”

#### **2/23 дугаар зүйлийн 23.12 дахь хэсэг:**

“23.12.Энэ хуулийн 23 дугаар зүйлд заасныг үл харгалзан өмч хувьчлалын орлогыг төсвийн орлого хэсэгт бүртгэхгүй төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр талд бүртгэнэ.”

#### **3/32 дугаар зүйлийн 32.2.21 дэх заалт:**

“32.2.21.энэ хуулийн 33.2.9-д заасан концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүний үндэслэл, тооцоо, Концессын тухай хуулийн 10.3-т заасан мэдээлэл.”

#### **4/33 дугаар зүйлийн 33.2.9 дэх заалт:**

“33.2.9.Концессын тухай хуулийн 4.1.2-т заасан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцөл/.”

**5/59 дүгээр зүйлийн 59.2.4 дэх заалт:**

“59.2.4.энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.”

**6/59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэг:**

“59.6.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас энэ хуулийн 59.1.3-т заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.”

**7/71 дүгээр зүйлийн 71.6 дахь хэсэг:**

“71.6.Энэ хуулийн 60.7 дахь хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалтын “тусламж, хандив”, 60 дугаар зүйлийн 60.2.5 дахь заалтын “хандив, тусламж” гэсний дараа “, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.21.Монгол Улсын Засгийн газраас тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд гадаадын тусламж авах асуудлаар хэлэлцээ хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах, гэрээ хэлэлцээрт Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах;”

**4 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1, 56.2.2 дахь заалтын “70 хувийг” гэснийг “60 хувийг 2017 оны төсвийн жилд, 40 хувийг 2018 оны төсвийн жилд, 60 хувийг 2019 оны төсвийн жилд, 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “хувьчилсан, худалдсан,” гэснийг хассугай.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 34.2 дахь хэсэг нэмсүгэй:

“34.2.Энэ хуулийн 9<sup>1</sup>.3.4 дэх заалтыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт нэмсүгэй:

**1/22<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“22<sup>1</sup> дүгээр зүйл.Оршин суугч бус албан татвар төлөгчийн  
Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогод албан  
татвар ногдуулах орлогыг тодорхойлох**

22<sup>1</sup>.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрт олсон орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

22<sup>1</sup>.2.Оршин суугч бус албан татвар төлөгчид орлого олгогч этгээд нь суутгагчийн үүрэг хүлээж энэ хуулийн 22<sup>1</sup>.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод албан татвар ногдуулж, суутгал хийнэ.”

**2/23 дугаар зүйлийн 23.2.4, 23.2.5 дахь заалт:**

“23.2.4.энэ хуулийн 18, 19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар;

23.2.5.энэ хуулийн 22<sup>1</sup> дүгээр зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 20 хувиар.”

**3/26 дугаар зүйлийн 26.1.7 дахь заалт:**

“26.1.7.суутгагч нь энэ хуулийн 22<sup>1</sup> дүгээр зүйлд заасан орлогыг оршин суугч бус албан татвар төлөгчид олгох тухай бүр энэ хуулийн 23.2.5-д заасан хувиар албан татвар ногдуулж, тухай бүр холбогдох төсөвт шилжүүлэх.”

**4/27 дугаар зүйлийн 27.1.5 дахь заалт:**

“27.1.5.гадаад улсад олсон энэ хуулийн 13.1.4-т заасан мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогод ногдох албан татварыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл энэ хуулийн 23.1-д заасан хувиар, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн энэ хуулийн 23.2.4-т заасан хувиар ногдуулан дараа сарын 10-ны дотор.”

**2 дугаар зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “орлогыг” гэсний өмнө “орлого болон мөнгөн хадгаламжийн хүүгийн” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“23.1.Энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд дараахь хувь хэмжээгээр тооцож, албан татвар ногдуулна:

Д/д	Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татварын хувь хэмжээ
1	18 000 000 хүртэл	10 хувь
2	18 000 000, түүнээс дээш 30 000 000 хүртэл	1 800 000 төгрөг дээр 18 000 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 15 хувийг нэмнэ.
3	30 000 000, түүнээс дээш 42 000 000 хүртэл	3 600 000 төгрөг дээр 30 000 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 20 хувийг нэмнэ.
4	42 000 000, түүнээс дээш	6 000 000 төгрөг дээр 42 000 000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 25 хувийг нэмнэ.

**4 дүгээр зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “84 000 төгрөгийн” гэснийг “120 000 төгрөгийн, 2019 онд 160 000 төгрөгийн, 2020 онд 200 000 төгрөгийн, 2021 оноос эхлэн 240 000 төгрөгийн” гэж өөрчилсүгэй.



**5 дугаар зүйл.**Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.16 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийн 2, 5 дугаар зүйл, 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс, 3, 4 дүгээр зүйл, 1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### **ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Онцгой албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 7.2 дахь хэсэг нэмсүгэй:

“7.2.Хос тэжээлт автомашин, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин, цахилгаан тэжээлт автомашины онцгой албан татварыг 50 хувиар хөнгөлнө.”

**2 дугаар зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчгийн “татвараас” гэсний дараа “хөнгөлөх,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг:**

“6.1.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-г заасан бараа болон эх орны үйлдвэрийн автобензин, дизелийн түлшний тогтоосон биет нэгжид дараахь хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:



Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл		Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/		
				2018	2019	2020 он ба түүнээс хойш
1	Хүнсний зориулалттай спирт	Согтууруулах ундааны үйлдвэрт худалдсан	1 литр	1 595	1 670	1 740
		Эмийн үйлдвэр, хүн, мал эмнэлгийн хэрэгцээнд худалдсан	1 литр	1 450	1 450	1 450
		бусад газарт худалдсан	1 литр	15 950	16 700	17 400
2	Бүх төрлийн цагаан архи, ликёр, кордиал ба спиртлэг бусад ундаа	25 хүртэл хатуулагтай	1 литр	3 190	3 335	3 480
		25-40 хүртэл хатуулагтай	1 литр	6 380	6 670	6 960
		40 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	14 355	15 000	15 660
	Бүх төрлийн коньяк, виски, ром, джин	25 хүртэл хатуулагтай	1 литр	7 975	8 340	8 700
		25-40 хүртэл хатуулагтай	1 литр	15 950	16 700	17 400
		40 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	19 140	20 010	20 880
3	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан эх орны үйлдвэрийн шимийн архи		1 литр	320	335	350
4	Бүх төрлийн дарс	35 хүртэл хатуулагтай	1 литр	800	835	870
		35 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	7 180	7 505	7 830
5	Бүх төрлийн пиво		1 литр	320	335	350
6	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи		100 ширхэг	3 830	4 000	4 180





7	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи		1 килограмм	2 870	3 000	3 130
8	Автобензин	90 хүртэл октантай	1 тонн	0-15 950	0-15 950	0-15 950
		90 ба түүнээс дээш октантай	1 тонн	0-17 400	0-17 400	0-17 400
9	Дизелийн түлш		1 тонн	0-21 750	0-21 750	0-21 750

**2/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:**

“6.3.Энэ хуулийн 4.1.4-т заасан суудлын автомашин импортлосон бол үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзан дараахь хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж /см³/	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
		Үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа /жилээр/			
		0-3 жил	4-6 жил	7-9 жил	10 ба түүнээс дээш жил
1	1500 ба түүнээс доош	750 000	1 600 000	3 350 000	10 000 000
2	1501-2500	2 300 000	3 200 000	5 000 000	11 700 000
3	2501-3500	3 050 000	4 000 000	6 700 000	13 350 000
4	3501-4500	6 850 750	8 000 000	10 850 000	17 500 000
5	4501 ба түүнээс дээш	14 210 000	27 200 000	39 150 000	65 975 000

**4 дүгээр зүйл.** Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 7.1.6, 7.1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийн 1, 2, 4 дүгээр зүйл, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс, 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Концессын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “Засгийн газар” гэсний өмнө “Улсын Их Хурал,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “төрийн өмчийн” гэсний өмнө “Төсвийн тухай хуулийн 33.2.9-т зааснаас бусад” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Концессын тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг:

“9.5.Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь концессын зүйлийн жагсаалтын талаархи саналаа энэ хуулийн 10.3-т заасны дагуу болон зардал, ашгийн тооцооны хамт боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр Засгийн газарт хүргүүлнэ.”

#### 2/10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг:

“10.1.Төсвийн тухай хуулийн 33.2.9-т зааснаас бусад төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг Засгийн газар батална.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

#### 1/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Энэ хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь дараахь хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй:



12.2.1. гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ;

12.2.2. тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол;

12.2.3. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;

12.2.4. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;

12.2.5. Засгийн газрын өрийн удирдлагын стратеги;

12.2.6. улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай;

12.2.7. Дайны байдлын тухай хуулийн 5.1, Дайн бүхий байдлын тухай хуулийн 5.1-д заасан Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;

12.2.8. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай;

12.2.9. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх;

12.2.10. энэ хуулийн 6.2, 6.3-т заасан тогтоолын төсөл;

12.2.11. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл батлах тухай;

12.2.12. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;

12.2.13. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай;

12.2.14. хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай;

12.2.15. төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл батлах тухай;

12.2.16. албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай.

### **2/38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг:**

“38.8. Энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно.”

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 дүгээр  
сарын 12-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт 2017 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 04 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар  
хот

### **Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасан албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор дараахь арга хэмжээг авч, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлэхийг үүрэг болгосугай:



1.1.нээлгэсэн банкны дансаа хаалгах;  
1.2.банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах;  
1.3.хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах;

1.4.хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох.

2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10<sup>1</sup>.3 дахь хэсэгт заасан жагсаалтыг 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор батлахыг Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн байнгын хороо /Ш.Раднаасэд/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар  
хот

### **Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 24 дүгээр бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



Бүлэг	Зүйл №	Үндэсний код	Барааны бичиглэл	Албан татварын хувь, хэмжээ
24	24.01		Түүхий тамхи; тамхины хаягдал.	30
	24.02		Тамхи эсвэл тамхи орлуулагч агуулсан сигар, үзүүрийг нь тайрсан сигар (cheroots) болон нарийн ороосон сигар (сигарилл) болон янжуур.	30
	24.03		Боловсруулсан бусад тамхи болон тамхи орлуулагч; “нэгэн төрлийн болгосон” буюу “сэлбэгдсэн” тамхи; тамхины ханд болон охь.	
			Задгай тамхи (тамхи орлуулагчийг ямар нэг хэмжээгээр агуулсан эсвэл агуулаагүй):	
		2403.11.00	Усан хоолойгоор татах зориулалттай тамхи	30
		2403.19	Бусад:	
		2403.19.10	Гаансаар татах зориулалттай дүнсэн тамхи	30
		2403.19.20	Янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхи	5
			Бусад:	
		2403.91.00	“Нэгэн төрлийн болгосон” эсвэл “сэлбэгдсэн тамхи”	20
		2403.99	Бусад:	
		2403.99.30	Хамрын тамхи	20
	2403.99.90	Бусад	20	

2.Энэ тогтоолыг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар  
хот**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1.1 дэх дэд заалтын “2017-2019 онд” гэснийг хассугай.

2.“Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1.2, 1.3 дахь дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА****М.ЭНХБОЛД****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**2017 оны 04 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар  
хот**Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай  
холбогдуулан авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг зорилгод бүлэгт чиглүүлж оновчтой байдлаар нэгтгэх, давхардлыг арилгах, хамрагдах шалгуур үзүүлэлтийг шинэчилж үр дүнг сайжруулах;

2/хүүхдийн мөнгөн тэтгэмжийг байнгын зорилтод бүлэгт чиглүүлэх замаар нийт өрхийн 40 хувийг хамруулах, гарах хэмнэлтийг хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрах хүрээ, багцын нэр төрлийг өргөжүүлэх, эмзэг бүлгийн орлого багатай өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд зарцуулах;

3/гол нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн төвлөрсөн худалдан авалтын тогтолцоог бий болгох, улсын эмийн бүртгэлд байгаа эмийн 10 хувийг эхний ээлжид төвлөрсөн худалдан авалтаар хэрэгжүүлж жил бүр энэ үзүүлэлтийг 10 хувиар нэмэгдүүлэх замаар 15 хувийн төсвийн хэмнэлт бий болгох;

4/төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх;

5/төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг 2017-2019 онд түр зогсоож, энэ талаар шийдвэр гаргахгүй байхыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгах;

6/эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2017-2019 онд өндөр насны тэтгэвэрт гарах 2 төрийн албан хаагч тутамд 1 албан хаагчийг нөхөн томилох, энэ хугацаанд бусад салбарт төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байж, ажил, үүргийн хуваарийг шинэчлэн оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, сул орон тоог зайлшгүй нөхөх шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх зарчмаар шийдвэрлэх;

7/улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах;

8/төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурлаас тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралт болгон батлахтай холбоотойгоор төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх үе шатанд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай бол төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;





9/өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж 2016 онд санхүүжилтээ бүрэн авч чадаагүй төсөл, арга хэмжээний хөрөнгийг шийдвэрлэх;

10/улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хийгдсэн төсөл, арга хэмжээний их засварын санхүүжилтийг нэмэгдүүлэх;

11/гадаадын хөрөнгө оруулалттай томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын гэрээний үр ашгийг дээшлүүлэх, борлуулалтын орлогыг Монгол дахь банкны дансаар дамжуулдаг болгож улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх;

12/өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг нэмсэн, хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдах хүүхдийн тоог бууруулсан нь иргэдийн хөдөлмөр эрхлэлт, амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлж байгааг хяналт, үнэлгээ хийж үр дүнг жил бүр Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд танилцуулж байх;

13/"Барих-Шилжүүлэх" нөхцөлтэйгээр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлах болсонтой холбогдуулан Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдах хүртэл дээрх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байх.

2.Энэ тогтоолын 1.12-д заасан танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай тохиолдолд саналаа Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 5.5

**Индекс: 200003**